



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 4/303

Алтай хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.4 дэх заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн аюулгүй байдал, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор сургууль, цэцэрлэг, сургалтын анги танхим, хүүхдийн тоглоомын талбай, хүүхэд зорчих зам, талбай, хүүхдэд хамаатай орчинд үзлэг шалгалт хийж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Мөнхжаргал -(Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд

Д.Төгсжаргал -(Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хүүхэд хамгааллын мэргэжилтэн, хүүхдийн эрхийн улсын байцаагч)

Д.Отгонжаргал-(Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний улсын хяналтын байцаагч)

Ц.Бадамгэрэл -(Мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)

Ц.Дэлгэрцэцэг -(Мэргэжлийн хяналтын газрын боловсрол, соёлын хяналтын улсын байцаагч)

Д.Лхасүрэн -(Цагдаагийн газрын хүүхдийн байцаагч)

Д.Майнбаяр -(Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Н.Цээпилмаа -(Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн, хүүхдийн эрхийн улсын байцаагч)

2.Хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулж, тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (С.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР